


МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 02 өдөр

Дугаар А/225

Улаанбаатар хот

Г

Мэдээлэл, сургалт, сурталчилгаа
зохион байгуулах тухай

Г

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.21, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолын 3.1.6-ийн 8, 2017 оны 11 дүгээр тогтоолын 3.5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. 2017 оныг “Нийгмийн эрүүл мэндийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан нийт хүн ам, ялангуяа эрсдэлт бүлгийн хүн амд БЗДХ, ХДХВ/ДОХ, сүрьеэгийн халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааны цогц ажлыг Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн санхүүжилтээр зохион байгуулсугай.
2. Мэдээлэл, сургалт, сурталчилгааны цогц ажлыг удирдлагаар хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн газар /Д.Ганцэцэг/, мэргэжил аргазүйгээр хангаж ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв /Б.Цогтбаатар/-д тус тус даалгасугай.
3. Мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг гүйцэтгэх байгууллагуудтай холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээ байгуулж, хамтран ажиллахыг Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, сүрьеэгийн төслийн зохицуулагч /А.Оюунбилэг/-д үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

080755